



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/39

Баян-Адарга

Г 7

Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5, дахь заалт 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6, дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4, дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/27 тоот тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/150 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтыг сумын бүх үхэр, гахайг хамруулах ажлыг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл нийт 27 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаал, стандарт ажиллагааны заавар, Хэнтий аймгийн мал эмнэлгийн газрын даргын тушаалын хүрээнд уг ажлыг шуурхай зохион байгуулах, дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, явцын болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг (Э.Оюунтунгалаг)-т, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын мэдээ тайлан, тушаалын хэрэгжилт, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Б.Баярцэцэг)-т, технологит хугацаанд мал үлдээлгүй дархлаажуулахыг Мал Эмнэлгийн Үйлчилгээний нэгжийн малын эмч нарт үүрэг болгосугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлдүүлэн, зарлан мэдээлэл хүргэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн Тасгийн дарга (Э.Оюунтунгалаг)-т үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг ханган ажиллахыг Засаг даргын тамгын дарга (С.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Ганбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.ЛХАГВАДОРЖ

